



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 8/4/8

Мөрөн сум

Захирамжийн хавсралтад өөрчлөлт  
оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.6, Захиргааны өрөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.4, 4.2.5, 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газар болон “Хөдөөгийн шийдэл” ОНӨХХК-иас ирүүлсэн хүсэлтийг үндэслэн аймгийн Засаг даргын 2022 оны “Шинэ хөдөө төслийн үйл ажиллагааны жагсаалт, төсвийн хуваарь батлах тухай” А/33 дугаар захирамжийн хавсралтын 14 дэх хэсэгт заасан “Малын зохиомол хээлтүүлгийн пункт” нийлүүлэх арга хэмжээний худалдан авах ажиллагаа нийт 8 удаа зарлагдсан боловч хуулийн этгээд шалгараагүй, мөн 15 дахь хэсэгт заасан “Малын тэжээлийн үйлдвэрийн тоног төхөөрөмж (бага овор)” нийлүүлэх арга хэмжээний худалдан авах ажиллагаа нийт 8 удаа зарлагдсан бөгөөд шалгарсан хуулийн этгээд нь нийлүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэний улмаас гэрээнээс татгалзсан байх тул аймгийн Засаг даргын 2022 оны А/33 дугаар захирамжийн хавсралтын “Зардлын утга” гэсэн хэсгийн “14. Малын зохиомол хээлтүүлгийн пункт” гэснийг “14. Зуны хүлэмж” гэж, “15. Малын тэжээлийн үйлдвэр (бага оврын)” гэснийг “15. Зуны хүлэмж” гэж тус тус өөрчлөлт оруулсугай.

2. Захирамжид өөрчлөлт оруулсантай холбогдуулан арга хэмжээг нээлттэй, ил тод хэлбэрээр худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсортодог)-т даалгасугай.

3. Дээрх арга хэмжээний ажил, үйлчилгээг үр дүнтэй зохион байгуулж, хэрэгжилтийг тухай бүр тооцож, хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа), Санхүү төрийн сангийн хэлтэс (Г.Базар) нарт тус тус үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газарт даалгасугай.

ДАРГА

ШИДЭРБАЯСГАЛАН



Захирамж-2022

6712011315

Аймгийн Засаг даргын 2022 оны  
...11... дүгээр сарын 23.. ний өдрийн  
А/418 дугаар захирамжийн хавсралт

№	Зардлын утга	Нийт үнэ
1	Махны чиглэлийн Сэлэнгэ үүлдрийн тугалтай үнээ, шүдлэн гунж худалдан авах	315,000,000
2	Махны чиглэлийн Герефорд үүлдрийн үржлийн шүдлэн бух худалдан авах	56,000,000
3	Махны чиглэлийн Сэлэнгэ үүлдрийн бухан бяруу	128,480,000
4	Бүл зэгийн тоног төхөөрөмжийн хамт худалдаж авах	100,000,000
5		
6	Газар тариалангийн зориулалтын трактор, техник, тоног төхөөрөмж дагалдах хэрэгсэл	380,000,000
7	Ашиглалтын зардал багатай эрчим хүч шатахуун зарцуулдаггүй эдийн засгийн хэмнэлттэй, инновацийн шийдэлтэй голоос тариалангийн талбайруу ус шахах услалтын систем худалдан авах	150,000,000
8	Хадлангийн нөөц бурдүүлэх, ногоон тэжээл тариалах иж бурдэл, тоног төхөөрөмж худалдан авах (Трактор, анжис, дөрвөлжин хаман боогч, урлон хаман боогч, дискэн хадуур, тармуур, үрлүүр, борной, хор цацагч)	1,610,000,000
9	Арьс шир боловсруулах тоног, төхөөрөмж худалдан авах	137,500,000
10	Дуслын усалгааны төхөөрөмжтэй зуны хүлэмж нийлүүлэх /4*8/	85,500,000
11	Дуслын усалгааны төхөөрөмжтэй зуны хүлэмж нийлүүлэх хүлэмж /8*20/	322,500,000
12	Талх, нарийн боовны тоног төхөөрөмж худалдан авах	83,000,000
13	Цагаан идээ боловсруулах тоног төхөөрөмж худалдан авах	12,000,000
14	Зуны хүлэмж худалдан авах	45,000,000
15	Зуны хүлэмж худалдан авах	60,000,000
16	Компьютер, принтер, техник хэрэгсэл худалдан авах	15,000,000
	<b>НИЙТ</b>	<b>3,499,980,000.00</b>

-----оо-----

